

ГАРЧИГ

<i>НЭГ. 2022 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i>	3
1.1. <i>Төслийн ерөнхий мэдээлэл</i>	3
1.2. <i>Уурхайн ашиглалтын систем, ажиллах горим, техник тоног төхөөрөмж</i>	5
<i>ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	9
<i>ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	11
<i>ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	11
<i>ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	11
<i>ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	11
<i>ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	12
<i>НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	12
<i>ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ</i>	13
<i>АРАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	15
<i>АРВАН НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	15
<i>ДҮГНЭЛТ</i>	15

ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

<i>Хүснэгт 1. Төслийн товч танилцуулга.....</i>	<i>3</i>
<i>Хүснэгт 2. Төслийн үндсэн тоног төхөөрөмжүүд.....</i>	<i>6</i>

ЗУРГИЙН ГАРЧИГ

<i>Зураг 1. Төслийн байршлын зураг</i>	<i>4</i>
<i>Зураг 2. Бутлан ангилах хэсгийн ерөнхий байдал</i>	<i>7</i>
<i>Зураг 3. Элсэн чулууг ангилан ялгах бутлах төхөөрөмжийн бүдүүвч</i>	<i>7</i>
<i>Зураг 4. Уурхайн талбайд байрлуулсан тэмдэг тэмдэглэгээ, аюулгүй ажиллагааны самбар.....</i>	<i>10</i>
<i>Зураг 5. Хог хаягдлын цэг</i>	<i>12</i>
<i>Зураг 6. Агаарын чанарын шинжилгээний хариу.....</i>	<i>13</i>
<i>Зураг 7. Хөрсний шинжилгээний хариу</i>	<i>14</i>

НЭГ. 2022 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Хүснэгт 1. Төслийн товч танилцуулга

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тайлбар
1	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	“СҮР СҮЛД” ХХК
2	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 20-р хороо, Бэлх Цуурайт 1, 184 тоот. Утас: 9534-7341
3	Төслийн нэр	“Зүүн түрүүн” нэртэй элсэн чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах
4	Хүчинтэй хууль эрх зүйн баримт бичгийн жагсаалт	1. Аж ахуй улсын бүртгэлийн гэрчилгээ: Улсын бүртгэлийн дугаар: 9011818030 Улсын регистрийн дугаар: 6570313 Улсад бүртгүүлсэн: 2020.05.08 2. Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл: Дугаар: 21/М037 Олгосон огноо: 2021.12.27
5	Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбайн солбицол	Газар зүйн солбицол: ТЗ: 21/М037 Талбай: 87.35 га 106° 38' 12.99" - 47° 55' 46.01" 106° 39' 24.99" - 47° 55' 46.01" 106° 39' 24.99" - 47° 55' 25.01" 106° 39' 01.05" - 47° 55' 25.01" 106° 39' 01.05" - 47° 55' 32.00" 106° 38' 39.74" - 47° 55' 32.00" 106° 38' 39.74" - 47° 55' 25.01" 106° 38' 12.99" - 47° 55' 46.01"
6	Ордын геологийн бодит (В) нөөц	Элсэн чулуу: 2 761.36 мян.м ³
7	Ордын үйлдвэрлэлийн нөөц	Элсэн чулуу: 2 753.06 мян.м ³
8	Жилийн хүчин чадал	Элсэн чулуу: 70.0 мян.м ³
9	Ордын ашиглалтын хугацаа	40 жил
10	Анхны хөрөнгө оруулалт	3 288.0 сая.төг

Төслийн байршил: Тус орд нь Улаанбаатар хотын төвөөс баруун хойд зүгт 21 км-т, УБ-Дархан чиглэлийн автозамын шалган бүртгэх 22-ын (шинэ) товчооноос чанх зүүн зүгт 3км-т Сонгинохайрхан дүүргийн 33-р хорооны нутагт оршино.




Төсөл хэрэгжих талбайн байршил

Сонгинохайрхан дүүрэг, 33-р хороо, “Зүүн түрүүн” нэртэй талбай



Таних тэмдэг

 Төсөл хэрэгжих талбай

1:25,000

1 см = 250 метр



Байгаль орчны зөвлөх үйлчилгээний
“Монслоу” ХХК-нд боловсруулав.

Зураг 1. Төслийн байршилын зураг

1.2. Уурхайн ашиглалтын систем, ажиллах горим, техник тоног төхөөрөмж

1.2.1. Ашиглалтын систем, ажиллах горим

Үйлдвэрлэл явуулах үндсэн шийдэл

Ордын нийт нөөцийг 2 761.36 мян.м³-ээр тооцжээ. Техник эдийн засгийн үндэслэлийг хийж гүйцэтгэхдээ захиалагч талын саналын дагуу олборлолтод DOOSAN DL300 маркийн экскаватор, HOWO 25 тн автосамосвалын хослол ашиглаж, мөн ZL50E маркийн утгуурт ашиглан жилд 70.0 мян.м³ элсэн чулууг ил аргаар олборлохоор төслийг боловсрууллаа.

Уурхайн өдөр тутмын үйл ажиллагааг шуурхай удирдлагаар хангах, техник тоног төхөөрөмжийг засварлах, тэдгээрийг хадгалах, үйлчилгээ материал хангамжийг газар дээр нь зохион байгуулах үүднээс уурхайн дэргэд захиргаа аж ахуйн байгууламж барьж байгуулна.

Уурхайн бүрэлдэхүүнд дараахь объектууд орно. Үүнд:

Үйлдвэрийн объектууд:

- ✓ Элсэн чулууг ангилан ялгах төхөөрөмж
- ✓ Сэлбэг хэрэгслийн агуулах
- ✓ Дизель станц,
- ✓ Бусад байгууламжууд г.м

Туслах объектууд:

- ✓ Захиргаа аж ахуйн байр, хоолны газар /нарядны өрөө/
- ✓ Ажилчдын байр
- ✓ Халуун усны байр
- ✓ Машин тоног төхөөрөмжийн түр гарааж /сарай/, засварын газар
- ✓ Харуул хамгаалалтын байр
- ✓ Бие засах газар
- ✓ Хамгаалалтын хашаа г.м

Уурхайн түр тосгон нь тусгай сонгосон талбайд байрлах ба объектууд 24 цагийн турш харуул хамгаалалтанд байна. Ажилчдын байр, халуун усны байр, захиргаа аж ахуйн байрыг тохижуулсан контейнер ашиглан бүрдүүлнэ.

1.2.2. Уурхайн ажиллах горим.

Үйлдвэрлэлийн ажиллах горим, ашиглалтын хугацааг уурхайн жилийн хүчин чадлаас хамааруулан тооцоолов. Ил уурхай нь улирлын чанартай дулааны улиралд (3-р сарын 15-наас 11-р сарын 15 хүртэл) 8 сарын хугацаанд жилд 172 хоног, хоногт 1 ээлж, ээлжинд 8 цагаар ажиллана.

УУРХАЙ НЬ:

ХӨРС ХУУЛАЛТ ►ӨРӨМДЛӨГ ТЭСЭЛГЭЭ►ЭЛСЭН ЧУЛУУ ОЛБОРЛОЛТ ►ТЭЭВЭРЛЭЛТ ► ЭЛСЭН ЧУЛУУГ БУТЛАХ, АНГИЛАН ЯЛГАХ, ► БЭЛЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭГЧДЭД АЧИЖ НИЙЛҮҮЛЭХ гэсэн технологийн үндсэн горимын дагуу ажиллана.

- ✓ Жилд ажиллах хуанлийн хоног – 243
- ✓ Засварт зогсох хоног – 16
- ✓ Амралт, баяр ёслолын хоног –46
- ✓ Цаг агаарын болзошгүй саатлын хоног – 9

- ✓ Жинхэнэ ажиллах хоног – 172
- ✓ Хоногт ажиллах ээлж – 1
- ✓ Ээлжийн үргэлжлэх хугацаа – 8 цаг
- ✓ Уурхайн ээлжийн тооцооны бүтээл – 406.97 м³/ээлж буюу 1086тн /ээлж

1.2.3. Уурхайн хүчин чадал, календарь төлөвлөгөө

Ил уурхайгаас жилд 70.0 мян м³ элсэн чулуу олборлон бутлаж, ангилан борлуулна. Зүүн ордоос олборлох магадлагдсан үйлдвэрлэлийн нөөц нь 2488.0 мян.м³, хөрс хуулалтын хэмжээ 70.2 мян.м³, хөрс хуулалтын дундаж коэффициент $k_{х.х}=0.03\text{м}^3/\text{м}^3$. Баруун ордоос олборлох магадлагдсан үйлдвэрлэлийн нөөц нь 265.0 мян.м³, хөрс хуулалтын хэмжээ 19.0 мян.м³, хөрс хуулалтын дундаж коэффициент $k_{х.х}=0.07\text{м}^3/\text{м}^3$ байна.

1.2.4. Төслийн тоног төхөөрөмж

Олборлолтонд 1.3 м³ утгуурын багтаамжтай HYUNDAI ROBEX 2900LC маркийн экскаватор, HOWO 25 тн автосамосвалын хослол ашиглаж, мөн ZL50E маркийн утгуурт ачигч ашиглан жилд 150.0 мян.м³ дайргыг ил аргаар олборлохоор төслийг боловсрууллаа.

Хүснэгт 2. Төслийн үндсэн тоног төхөөрөмжүүд

№	Процессууд		Тоног төхөөрөмж	
	Нэр	Горим	Нэр	Горим
1	Өрөмдлөг	сард 1удаа	Өрмийн машин	Өрөмдлөг тэсэлгээний ажлыг гэрээ, захиалгаар мэргэжлийн үйлчилгээний байгууллагаар хийлгэнэ.
2	Тэсэлгээ	сард 1удаа		
3	Экскаваци	Хоногт 1 ээлж	Экскаватор	1. Ээлжинд ногдох үндсэн ажил 6.5цаг 2.Ээлж хоорондын завсарлага ба техникийн үзлэг үйлчилгээний 1.5 цаг
4	Тээвэр	Хоногт 1 ээлж	Автосамосвал	
5	Овоолго	Хоногт 1 ээлж	Шууд утгуурт ачигч	

Ангилан ялгах тоног төхөөрөмжийн технологийн схем

Бутлан ангилж, ялгах хэсэгт ажиллах тоног төхөөрөмжүүдийн техникийн бүтээмжүүдийг авч үзвэл:


- ✓ Түүхий эд хүлээн авах бункер 100 м³/цаг
- ✓ Тэжээгүүр 80-100 м³/цаг
- ✓ Хацарт бутлуур 75-90 м³/цаг
- ✓ Конусан бутлуур 70-75 м³/цаг
- ✓ Туузан дамжуулга 75-90 м³/цаг
- ✓ Шигшүүр 80-90 м³/цаг

байгаа нь тоног төхөөрөмжүүдийн хоорондын уялдаа тохирч байгаа ба хэсгийн хамгийн бага бүтээмж нь конусан бутлуурын бүтээмжээр хязгаарлагдахаар байна.



Зураг 2. Бутлан ангилах хэсгийн ерөнхий байдал

Бутлан ангилах технологийн схем



Зураг 3. Элсэн чулууг ангилан ялгах бутлах төхөөрөмжийн бүдүүвч

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байдал
1	Уурхай орчимд тоосжилт үүсэх	Уурхайн ам орчимд болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах, дагтаршуулах	Уурхайн карьер болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн.
2		Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх	ОХШХ-ийн дагуу хяналт шинжилгээг хийлгэсэн.
1	Ашиглаж буй усны чанар муудах, хүрэлцээ бага байх	Ус ашиглах дүгнэлтийг жил бүрийн эхэнд гаргуулах	Ус ашиглах дүгнэлт гаргуулсан.
2		Ус ашигласны төлбөрийг цаг тухайд нь тогтмол хугацаанд төлөх	
3		Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх	Усны шинжилгээ хийлгэсэн.
1	Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс овоолго, уурхайн тосгон, бусад байгууламжуудын дор дарагдаж, элэгдэл, эвдрэлд өртөнө.	Овоолго болон бусад байгууламжуудыг байгуулахын өмнө өнгөн хөрсийг хуулан авах,	Шимт хөрсний овоолго үүсгэн хадгалсан.
		Хуулж авсан өнгөн хөрсийг тусгайлан овоолго байгуулан хадгалах	
		Шимт хөрсний үржил шимийг алдагдахаас хамгаалж, өндөрлөж овоолго үүсгэх болон дагтаршуулахгүй байх	
2	Уурхайн замын ачааллаас хөрс элэгдэж, эвдрэлд орох	Хүнд машин механизм явах замыг засаж сайжруулан, байгалийн хөрс бүхий замаар тээвэрлэлт аль болох бага хийх	Уурхайн карьер болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн.
1	Элсэн чулуу олборлосноор газрын хэвлийд хоосон орон зай шинээр үүсгэнэ.	Уурхайн малталтууд болон олборлосон орон зайд бэхэлгээ, хамгаалалтын цул зэргийг үлдээж нуралт үүсэхээс сэргийлнэ	Уурхай орчимд тэмдэг тэмдэглэгээ байршуулсан.
1	Уурхайгаас олборлосон элсэн чулууг бутлах, ангилах зэрэг ажлын үед ургамал устах, дарагдах, талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөнө.	Нөхөн сэргээлтэнд ашиглах хөрсний шимт хэсгийн овоолгыг стандартын дагуу тусгайлан овоолж, салхинд хийсэхээс хамгаалах.	Шимт хөрсний овоолго үүсгэн хадгалсан.
2		“Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн талбайд 50 ш мод тарих	Уурхайн талбайд мод тарих ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.
1	Амьтны аймагт хохирол учруулах, тоо толгой хорогдох, идэш тэжээлийн хомсдол үүсэх	Мал амьтан өнгөрч гардаг хэсгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, Авто машины хурдыг тогтоосон хязгаарт байлгах	Уурхай орчимд тэмдэг тэмдэглэгээ байршуулсан.



Зураг 4. Уурхайн талбайд байрлуулсан тэмдэг тэмдэглэгээ, аюулгүй ажиллагааны самбар

ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй болно.

ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-тай хамтран ажилласан бөгөөд уг ажлын зардал болох 2.0 сая төгрөгийг шилжүүлсэн.

Худалдаа Хөгжлийн Банк		Огноо: 2022.10.03 11:43:09		
Шилжүүлгийн мэдээлэл Журналын №: 75384595				
Системийн огноо: 2022.10.03				
Нэр: СҮР СҮЛД ХХК				
Илгээгч	Дансны дугаар: 440000343	Нэр СҮР СҮЛД ХХК	Дүн 2,000,000.00 MNT	Ханш 1.00
/ хоёр сая төгрөг /				
Хүлээн авагч	Банкны дугаар: 05 Дансны дугаар: 5754001012	Банкны нэр Хаан Банк Нэр БАГАХАНГАЙ ТОХИЖИЛТ ОНӨААТҮГ	2,000,000.00 MNT	1.00
Гүйлгээний үтгэ: EB -Sur Suld XHK duitsuulen hamgaalah zardal				
Танд баярлалаа				

ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 онд нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй.

ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Сүр сүлд” ХХК-ны тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн олдворын ул мөр ажиглагдаагүй байна. Түүнчлэн археологийн дурсгал илрээгүй байна.

ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Төлөвлөгөөний биелэлт
1	Гал түймэр	Галын булан байрлуулах	Уурхайн тосгон	Галын булан байрлуулсан.
		Аваар устгах төлөвлөгөө боловсруулах	Уурхай	Аваар устгах төлөвлөгөө боловсруулж батлуулан, аюул осолгүй ажилласан.
2	Тэсрэх бодис	Мэргэжлийн гэрээт байгууллагаар тэсэлгээний ажил гүйцэтгүүлэх	Тэсэлгээний ажлын үед	Тэсэлгээний ажлыг мэргэжлийн байгууллагаар гэрээний дагуу хийж гүйцэтгүүлсэн.
		Тэсрэх бодисын тоо бүртгэлийг тогтмол хийх		
		Тэсрэх бодисын үлдэгдэл, сав баглаа боодлыг гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан аюулгүй болгох		

НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


Хог хаягдлын гэрээг Сонгинохайрхан дүүргийн “Тохижилт үйлчилгээний газар”-тай байгуулж, гэрээний дагуу сар бүр тогтмол тээвэрлүүлэн ажилласан. Мөн хог хадгалах түр цэгийг тохижуулсан.



Зураг 5. Хог хаягдлын цэг

ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

ОХШХ-ийн хүрээнд уурхай болон бутлан ангилах үйлдвэр, ажилчдын тосгон орчмоос агаарын чанарын болон хөрсний бохирдлын дээжийг жил бүр авч шинжлүүлж байна.




MNAS
Accreditation
system
T1, 08
MNS ISO-TEC

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt1@gmail.com

СОРИЛТЫН ДҮН




БАЙГАЛЬ
ОРЧИН ХЭМЖИЛЭЭНИЙ ТӨВ ЛАБОРАТОРИ

Дугаар он/№	: 2022/А-281
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Сур Сүлд” ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал	: Д.Сувд агаарын хэсэг
Дээжийн тоо, төрөл	: 1 агаар, 1 дуу чимээ
Сорьц авсан огноо	: 2022.09.23
Дээжийн тодорхойлолт	: СХД 32-р хороо дайрганы карьер
Шинжилгээний аргын стандарт	: MNS 0017-2-5-12:2021, MNS 0017-2-5-11:2021
	CA3 A07-2016
Шинжилсэн огноо	: 2022.10.04
Хуудасны тоо	: 1/1
Үр дүн :	

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Нийт Тоос /TSP/ мг/м ³	Дуу чимээ
1	Уурхайн салхин доороос	IX/23	15:00	0.015	0.024	0.155	/ДБА/
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн:
Агаарын хэсгийн инженер

Хянаж баталгаажуулсан:
Агаарын хэсгийн инженер




Э.Оюунтуяа

Д.Түмэндэлгэр

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

Зураг 6. Агаарын чанарын шинжилгээний хариу




МНАС
Accreditation
system
TL 09
MNS ISO/IEC

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com

СОРИЛТЫН ДҮН



БАЙГАЛЬ
ОРЧИН ХЭМЖИЛЭЭНИЙ ТӨВ ЛАБОРАТОРИ

Дугаар он/ №	: 2022/ 554
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Сүр Сүлд” ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал	: Д.Сувд, агаарын хэсгийн техникч
Дээжийн тоо, төрөл	: 1, хөрсний сорьц
Хүлээн авсан огноо	: 2022.09.30
Дээжийн тодорхойлолт	: Улаанбаатар хот -СХД, 32-р хороо, Дайрганы ка
Шинжилгээний аргын стандарт	: MNS 3310:1991
Шинжилсэн огноо	: 2022.10.06
Хуудасны тоо	: 1/1
Үр дүн:	


№	Сорьц авсан цэг	Чийг %	pH	Ялзмаг %	Аммоны азот (NH ₄ -N) мг/кг	Нитратын азот (NO ₃ -N) мг/кг	Фосфор (P ₂ O ₅) мг/кг	Сульфат (SO ₄) мг/кг
1	Талбайн голоос	2.86	7.50	1.84	54.6	10.2	95.2	178.4

Шинжилгээ гүйцэтгэсэн : *Н.Эрдэнэсүрэн*

Хөрсний хэсгийн техникч

Хянаж баталгаажуулсан : *Б.Даваасүрэн*

Хөрсний хэсгийн инженер



Н.Эрдэнэсүрэн

Б.Даваасүрэн

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн дээжинд хүчинтэй

Зураг 7. Хөрсний шинжилгээний хариу

АРАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасны дагуу 2022 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, БОМТ-г боловсруулан батлуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан. Түүнчлэн уурхайн ажилчдыг ХХАА-ны хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан болно.

АРВАН НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулан БОАЖЯ-ны цахим системд илгээсэн ба НБОГ-т хэвлэн бэлтгэж, танилцуулахаар хүргүүлсэн болно.

ДУГНЭЛТ

Манай компани нь 2022 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Тоосжилт ихтэй үед зам усалгааг тогтмол хийж байсан.
- ✓ Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд НБОГ-тай хамтран ажилласан. Уг ажлын зардалд 2.0 сая төгрөг зарцуулсан болно.
- ✓ Хог хаягдлын гэрээ байгуулж, гэрээний дагуу тээвэрлүүлж байсан. Түүнчлэн хог хаягдлыг түр хадгалах цэгийг байгуулсан.
- ✓ Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан.
- ✓ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаарын чанар, дуу чимээний хэмжилт хийлгэж, хөрсний шинжилгээ авч лабораторид шинжлүүлсэн.

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр хийгдэх ёстой ажлуудыг цаг тухайд нь 100 хувь хийж гүйцэтгэсэн болно.